

Эртний монгол овгийн бэлгэдэлүүд

Төрбат Ц.

XII-XIII зууны зааг үе буюу Монголын эзэнт гүрэн байгуулагдахын өмнөх монгол үндэстний хөгжлийн төлөв байдлыг авч үзвэл овгийн байгуулал задарч улмаар ангит нийгэмд шилжин орж байв хэмээн манай түүхчид үздэг билээ. Энэ овог нь чухам ямар төрх байдалтай байсан асуудал түүхийн судалгаанд чухалчлан үзүүштэй зүйлийн нэг мөн байна. Манай зарим эрдэмтэд, түүний дотор, доктор Л.Билэгт эртний монгол овгууд нь хүй нэгдлийн нийгмийн үеийн овгоос олон талаараа ялгаатай, хөгжлийн өөр шатны угсаатны нийтлэг мөн хэмээн үзэж иржээ¹. Үүнтэй холбогдон овгийн байгуулалын өвөрмөц нэгэн шат “нүүдэлчдийн овог”-ийн тухай асуудал ч гарч ирж байгаа юм. Хөгжлийн энэ шат Хүннүгээс Манжийн үе хүртэл бараг хоёр мянган жилийн турш онцын өөрчлөлтгүйгээр хадгалагдан ирсэн түүхэн үзэгдэл мөн байна.

Б.Я.Владимирцов анх “Монголчуудын нийгмийн байгуулал ба Монголын нүүдлийн феодализм” хэмээх алдарт зохиолдоо овог бол дундад зууны Монголын нийгмийн зохион байгуулалтын үндсэн элемент мөн хэмээн үзжээ². Бид түүний энэхүү санааг гүнзгийрүүлж үүний өмнөх нэгэн судалгаандаа нүүдэлчдийн бүх төр улс тодорхой нэгэн овог, түүнийг тойрон хүрээлсэн овгуудын нэгдэл байдлаар бүрэлдэн үүсч байсан механизмийг толилуулсан билээ³. Үүнийг товчлон үзүүлбэл, Хүннүгийн – суюляньти буюу люаньди овог, Сяньбийн – тоба, муюн зэрэг овог, Жужаны – нирун, татар зэрэг овог, Түргийн – ашина овог, Уйгурын – яглакар овог, Киданы – елюй овог, Зүрчидийн – ваньянь овог, Монголын – боржигид овог, Манжийн – айсин гиоро овог зэрэг нь бүгд төр улсыг үндэслэн байгуулсан, төрийн тулгуур болсон ноёлох овгууд болох юм. Эдгээр овгууд тус бүрдээ байнгийн худ ургийн харилцаатай нэг болон хэд хэдэн овогтой байх бөгөөд эдгээр худ овгоос төрийн зүтгэлтэн язгууртнууд гарах учиртай байна. Нүүдэлчдийн төрийн бүрэлдэхүүнд багтан орсон бусад овог аймгууд

¹ Л.Билэгт. *Род и племя в устной истории монголов*. – Археологийн судлал. Боть XIX, Дэвтэр 12, УБ., 1999, т. 120.

² Б.Я.Владимирцов. *Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм*. Ленинград, 1934, стр.70.

³ Н.Сүхбаатар, Ц.Төрбат. *Генеалогийн ухаан ба Ойрад язгууртнуудын уг гарлын асуудал*. – *Түүхийн хавсрага ухаан*. Ред. Ж.Болдбаатар. УБ., 2003

бүгд ноёлох овгийн эрхшээлийг хүлээн зөвшөөрөх бөгөөд дараагийн нэгэн овог мандан гарч ирж өмнөхийг унагаахад мөн л онцийн эсэргүүцэлгүйгээр (!) шинэ ноёлох овгийг хүлээн зөвшөөрч даган захирагддаг байжээ. Ерөнхийлөн хэлбэл, нүүдэлчдийн төр улсын түүх бол нэг талаасаа ноёлох овог аймгуудын түүх мэт байна.

Нүүдэлчдийн овгийг бүх талаас нь судлах бодит шаардлага байсаар байна. Түүний дотор овгийн дотоод нэгдлийн бэлгэ тэмдэг, гадаад илрэх хэлбэрийн символуудыг судлах шаардлагатай. Доктор Д.Гонгор энэ талаар шинжлэн үзээд эртний монгол овгийн үндсэн шинжүүдийг доорхи мэтээр сэргээжээ. Эдгээр нь, нийтлэг өвөг дээдэстэй, тусгай нэр цол хочтой, нийтийн нутагтай, гал голомт нэгтэй, нийтийн оршуулгатай, нийтийн хурал цуглаантай, нийтийн хурим, дуу бүжигтэй, удам судрыг өгүүлсэн угийн бичигтэй, сүлд туг, онго шүтээн, уриа хашгираатай, им тамгатай, өв хөрөнгөтэй, нийтийн шүтлэг бишрэлтэй, нийтээр дагаж мөрдөх өвөрмөц ёс заншилтай зэрэг шинжүүд болох ажээ⁴. Эдгээр шинжүүдээс зарим нэгийг нь монгол овгийн бэлгэ тэмдэгийн зүйл хэмээн үзмээр байна. Тухайлбал, сүлд туг, уриа хашгираан, им тамга гурав бол тухайн овгийг бусдаас ялгаруулдаг гадаад хэлбэрийн зүйл бөгөөд даруй овгийн бэлгэ тэмдгүүд мөн юм. Эдгээрээс гадна монгол овгийн бэлгэ тэмдгийн нэгэн зүйл нь шувуу байсан бололтой. Цагаан шонхор шувуугаар хиад боржигид овгийг бэлгэдсэн тухай нэгэн өгүүлэмж Монголын нууц товчоонд гардагийг судлаачид ажиглаад энэ нь хиад боржигид, цаашилбал нийт монголчуудын шүтээн болсон шувуу мөн хэмээн үзсээр иржээ. Цагаан шонхор шувуу нийт монголчуудын шүтээн бөгөөд бэлгэ тэмдэг мөн гэж үзэх нь хожуу үеийн ойлголт бололтой. Харин зөвхөн хиад боржигид овгийн бэлгэ тэмдэг болсон шувуу мөн гэдэг нь эргэлзээгүй байна. Иймээс эртний монгол овог тус бүр өөрийн бэлгэ тэмдэг болсон сүлд туг, уриа хашгираан, им тамга, шувуу гэсэн дөрвөн зүйлтэй байжээ хэмээн үзэж болохоор байна.

Мөн Х.Пэрлээ абугай “овгийн сүлд, овгийн шүтлэг, цэрэг буюу цэрэв мод (хэц мод), онго тахилгын махнаас хувьд хүртэх мөч, чац, овгийн тулалдааны уриа хашгираа тус тусдаа”⁵ байсан болохыг тэмдэглэн үлдээжээ.

Бид зарим нэгэн сурвалжийн мэдээнд түшиглэн эртний нүүдэлчдийн овгийн бэлгэ тэмдгийн зүйлийг дахин нэгэн зүйлээр нэмэх саналыг энэхүү илтгэлд дэвшүүлж байна. Зохиогч тодорхойгүй “Дефтери-Чингиз-намэ” гэсэн нэртэй XVII зууны үеийн нэгэн татар сурвалжид Чингис хаан өөрийн ноёдол соёрхол хүртээж байгаа тухай нэгэн өгүүлэмж байна. Тэнд гарч байгаа ноёдын нэр нь Монголын түүхийн сурвалжуудад гардаг бодит хүмүүс бус харин зарим нэгэн овгуудын нэрс байгаа нь сонирхолтой. Ер нь уг сурвалжийн агуулга нь ихэд лалын шашны домог зүйгээр гуйвагдсан, түүхэн үйл явдлын он цагийг хольж, хүн ба овгийн нэрсийг хутгасан байдал үзэгдэвч зарим нэгэн мэдээг нь огт үгүйсгэж болмооргүй сонирхолтой байна. Сурвалжид өгүүлэхдээ: “Түүний хойно Жингиз хаан тэрхүү ноёдын хэсэгт тус бүрт нь тамга, шувуу, мод уриа өгч багц нэгдмэл ард болгон салгав. Урьд эхэлж Бодонжарын хөвгүүн Кыяат-д айлдав: Чиний мод чинь харгай болог. Шувуу чинь шонхор болог. Уриа чинь Ару Жаан болог. Тамга чинь чөдөр өвс болог. өөрөөр хэлбэл өвсөн тамга болог хэмээв. Дүрс нь энэ

⁴ Д.Гонгор. *Халх товчоон: Халх монголчуудын нийгэм-эдийн засгийн байгуулал (XI-XVII зуун)*. 2-р боть. УБ., 1978, т. 8-9.

⁵ Х.Пэрлээ. *Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь*. УБ., 1975, т. 8.

буюу ^Х Мөн түүний хойно Жингиз хаан Конграт ноёны хөвгүүн Сэнглэ-д айлдав: Аяа Сэнглэ чиний мод чинь алимны мод болог. Шувуу чинь начин болог. Уриа чинь Конграт болог тамга чинь саран тамга болог Дүрс нь энэ буюу ^О Мөн Жингиз хааны өөрийнх нь уриа нь Жаан Каба хэмээх бөлгөө. Жингиз хааны энэхүү дурдсан ноёд бүр дагалдагч дарга хийж цэрэг авч мордох бөлгөө. Тэр их хүнд цагт ард түмэн нэг нэгнээ уриа уриагаар нь олох бөлгөө” гэж гарч байна⁶.

Өөр бас нэгэн зохиолд үүнтэй төстэй мэдээ гарч байна. Энэ бол Казахын ардын уран зохиолч, түүхч Шакирам Кудайберды-улы гэдэг хүний 1911 онд казах хэлээр хэвлүүлсэн “Тюрк, киргиз, казах ба хаадын угсаа залгамжлалын угийн бичиг”⁷ нэртэй зохиол юм. Зохиолд өгүүлснээр бол: “Чингис хан их хаанаар өргөмжлөгдсөний дараа овог аймгуудын удирдагч нарт уриа хашгираан, шувуу, мод, тамга гэсэн ялгах тэмдгүүдийг соёрхсон гэнэ. Ингээд Их жузын ахлагч уйсун овгийн Майкы ноёнд үүнээс хойш чиний уриа хашгираан – салават, шувуу чинь бүргэд, мод чинь харгай, тамга чинь “сургу” болно. Дундад жузын ахлагч конрат овгийн Сенгел ноёнд үүнээс хойш чиний уриа хашгираан чинь конырат, шувуу чинь шонхор, мод чинь алимны мод, тамга чинь саран болно”⁸ гэжээ.

Мөн Башкирын хуучин үгэнд “Чингис хаан башкирийн ноёдод тусгай тамга, уриан мод (хэц мод), шувуу хайрласан гэж домоглодог”⁹ тухай Х.Пэрлээ өгүүлжээ.

Эдгээр сурвалжийн мэдээ бараг ижил байгаа нь тэдний үнэн бодитойд эргэлзэх зүйлгүй болгож байна. Хэдийгээр монгол сурвалжуудад ийм мэдээ үгүй боловч нүүдэлчдийн хүрээнд, ялангуяа монгол овог аймгууд ихэд оролцож холилдсон татар, казах, башкир нүүдэлчдийн дотор ийм нэгэн ойлголт байсан нь монгол овгийн бэлгэ тэмдгүүдийг: мод, шувуу, уриа хашгираан, тамга, магадгүй сүлд туг гэсэн таван зүйлээс бүрддэг байжээ гэж үзэхэд хүргэж байна.

⁶ Б.Аззаяа. “Дефтери-Жингиз-намэ” зохиолд хийсэн эх бичгийн судалгаа.” МУИС. Бакалаврын дипломын ажил. УБ..2005.

⁷ Шакарим Кудайберды-улы. *Родословная тюрков, киргизов, казахов и ханских династий*. Перевод Б.Каирбекова. Алма-Ата. 1990.

⁸ Мөн тэнд. Стр. 21-22.

⁹ Х.Пэрлээ. Дурдсан зохиол.т.66.

Зохиогч тодорхойгүй “Дефтери-Жингиз-намэ” зохиолд тэмдэглэгдсэн овгийн бэлгэдлийн зүйлс [Б.Азаяа. “Дефтери-Жингиз-намэ” зохиолд хийсэн эх бичгийн судалгаа. МУИС. Бакалаврын дипломын ажил. УБ.,2005].

№	Хүний нэр буюу Овгийн нэр	Мод	Шувуу	Уриа	Тамга	
1	Бодонжарын хөвгүүн Кыяат	Харгай	Шонхор	Ару жаан	Чөдөр өвс	Х
2	Конграт ноён хөвгүүн Сэнглэ	Алимны мод	Начин	Конграт	Саран	О
3	Уяшын Маякы ноён	Хар мод	Хар шувуу	Салават	Шөрөг	Ш
4	Ордаж	Хус	Харцага	Алаж	Шувуун хавирга	Ш
5	Тамяан	Улиангар	Хяргуй	Тутяа	Дэгээ	Д
6	Кыпчак	Хайлаас	Бүргэд	Ток саба	Сам	Д
7	Жорматы	Уд	Идлэг шонхор	Ак тайлак	Сынлы синек	У
8	Кэрэйт	Далдуу мод	Галуу	Ар бөрү	Нүдэн тамга	А
9	Мутяан	Хадыр	Тогоруу	Баягонграт	Куюушган	У
10	Буржан	Царс	Күчүгэн	Актоган	Жагалбай	Ц
11	Боркыт	Агч	Өвөөлж	Буруж	Хамза	Б
12	Кагыр-жарын хөвгүүн Кагая	Арц	Өрөвтас	Тайлак	Сэрү	Т
13	Калдар	Зандан	Тагтаа	Арнав	Бүтээгч	С
14	Салжут	Яшил	Алтан гургалдай	Барлас	Байшин	О
15	Тэмир Кутлу	Нигүрс	Шаазгай	Табан	Хагас сам	Т
16	Жингиз хан			Жаан каба		

ABSTRACT

Symbols of Ancient Mongolian Tribes

The author has analyzed a manuscript written in tatar in 17th century “Dafter-i Cingiz name” (anonymous) and an other manuscript written in kazakh in 1911 by Shakiram Kudayberdy-uly “Shejire of Turks, kirgizs and kazakhs and genealogy of khans” concerning the history of mongolian and turkic tribes. According them the symbols of ancient mongolian tribes were: a tree, a bird, a tamga, a fight shouting and a sulde-flag.